

ОЙРХИ ДОРНОДЫН ХЯМРАЛ: ТҮҮХ, ОРЧИН ҮЕ

О. Чимэгмаа*

Канадын Квебекийн Лавалын их сургуулийн судлаачдын 2001 онд гаргасан тооцоогоор дэлхийд их бага 140-өөд зэвсэгт мөргөлдөөн бүртгэгдсэн байна. Эдгээрийн ихэнх нь улс орон хоорондын бус улс доторх ястан үндэстний зөрчилдөөн, шашин шүтлэгийн ялгаа зэргээс үүдэн гарч байна. Зэвсэгт мөргөлдөөн, дайн дажин бүрийн үндэс язгуур шалтгааныг судлан үзэх тусам аллага хядлага, мөргөлдөөн гэгч ямар ч утгагүй зүйл болох нь илэрхий.

Дэлхийд гарч буй зэвсэгт мөргөлдөөний хамгийн хүнд, хор хохирол ихтэй, олон жил үргэлжилж буй мөргөлдөөний нэг нь Арабын ертөнц дэх Палестин Израйль хоёрын дайсагналшлал мөнөөс мөн.

Энэхүү мөргөлдөөн олон эхийг үрээс нь салгасан, олон хүүхдийг эцэг эхээс нь өнчрүүлсэн, хүний гар ур ухааны олон гайхамшгийг сүйтгэн устгасан аймшиг мөн. Энэ асуудлыг авч үзэхийн тулд энэхүү 2 үндэстний түүхийн хуудсыг эргүүлэн үзэх шаардлагатай ажээ. Өнөөдөр манай зарим залуус харамсалтай нь араб ертөнцийг алан хядлага, эмэгтэй хүнийг үл хүндэтгэсэн, соёл иргэншлээс хоцорсон мэтээр нийтлэгшүүлэн төсөөлдөг нь туйлын харамсалтай. Араб ертөнц бол асар их гайхамшигт уран барилга, яруу найраг, уран зохиол, оюуны бүтээлийг туурвисад, дэлхийд анхны иргэншлийн эх үүсвэр болох хотыг¹ бий болгосон болоод хүний түүхэнд анх араб бичгийг² үүсгэсэн их түүх соёлын эзэд мөн.

Эрт дээр үеэс Газар дундын тэнгисийн зүүн эрэгт (Одоогийн Израйль, Сири, Ливаны нутаг) еврей нар лалын шашинтай араб нартай эв найрамдалтай амьдарсаар иржээ. 13-р зуунаас энэ найрсаг байдал эвдэрч эхлэв. Еврей нар Өрнөдийн соёл иргэншилд олноороо татагдаж европжиж байлаа. Европын соёл иргэншлийг арабууд алсдаа колоничлогдох аюул хэмээн үзэж эхэллээ. Эдүгээ үед Европын соёл иргэншил дэлхийг хамрах болсон нь араб ертөнц дэх үндсэрхэг үзлийг улам гааруулсаар байна. Библи сударт тэмдэглэснээр Еврей, Араб хоёр үндэстэн гарал угсаа нэгтэй хоёулаа Абрахамын үр удмынхан ажээ. Лалын шашны эцэг Мохамед ч Библи судраас эх сурвалжаа авсан гэдэг. Лалын Коран судар, Библи хоёрт хоёуланд нь ижил төстэй өгүүлэл, тэмдэглэл, ёс, захиас элбэг тохиолддог.

*О.Чимэгмаа - Францын Тулуз хотын их сургуулийн докторант

Арабууд гэж хэн бэ?

МЭӨ YIII-YI зуунд Арабын хойгийн хойт хэсэгт амьдарч байсан Араб хэмээх нүүдэлчин овгийн нэр Вавилон, Ассирийн хаадын түүхэн сударт тэмдэглэгджээ. Тэд өөрийн хэл, соёл, ахуй байдлаараа бусад овгийнхноос онцлогтой байв. Хожим нь тэд нүүдэллэн өргөжиж Ойрхи Дорнодоос Сири, Турк, Ливанаар дамжин Хойд Африкт, өмнө зүг Оман, Йемен хүртэл тархан суурьшжээ. МЭ-ийн YI-YIII зуунд арабууд Хойт Африкаас Испани, Францын өмнөд нутгийг байлдан дагуулж байлаа.

Еврей нар –135 онд Ромын эзэнт гүрэн Ерусалимийг эзлэн сүйтгэсэн нь еврей нар олноороо Хойд Африк, Вавилон, Европ руу дайжин зугатах эх үндсийг бий болгожээ. 17-р зуунаас цагаачлан гарсан еврей иргэд европ даяар тархан суурьшиж өрнөдийн аж амьдралд дасан зохицож амьдарч байвч өөрсдийн хэл соёл, зан заншлаа хамгаалан амьдрах зорилгын улмаас 1860 оноос эхлэн еврейн холбооны сургуулийн үндсийг тавьсан нь улмаар өргөжиж 1864 онд Иракт, Сирид, 1867 онд Грек Туркэд, 1870 онд Палестинд, 1878 онд Тунист, 1890 онд Ливи, 1894 онд Алжирт, 1896 онд Египетид, 1898 онд Персид тус тус еврейн сургууль байгуулагдав.

Ийнхүү еврей нар үндэс угсаагаа газар сайгүй бататгасаар соёл боловсролоороо онцгойрч ирсэн нь нутгийн араб нарын дургуйшлийг төрүүлэв. Араб орнууд дахь еврей нар нутгийн соёлыг хүлээн авч ёсоор нь амьдрахыг үл зөвшөөрөн европ маягаар амьдарч европ хэлээр ярьж өрнөд маягаар хувцаслаж эхэлсэн нь нутгийн араб нарын хорслыг улам дэвэргэв. Еврей нар европын соёлд татагдан уусч байсан нь олон шалтгаантай. Тэд араб нарт уусан татагдахгүйн эрхээр, төрөлх нутаасаа алслагдан тархан амьдарч ирснээр ийнхүү өргөжижээ.

18-р зуунаас эхлэн Европын гүрнүүд дэлхийг хуваан колончилож эхэлэхэд еврей нар өрнөдийнхөнтэй нэгдэв. Энэхүү байдлыг нутгийн иргэд ихэд дургүйцсэний илрэл нь 1870 онд Алжирт гарсан еврейн эсрэг бослого юм. Алжир Францын колони байх үед алжирийн еврей нар Франц колоничлогчтой илт нэгдсэн ажээ.

Ийнхүү 1870-аад оноос эхэлсэн еврейн эсрэг хөдөлгөөн хаа сайгүй өрнөж эхлэв. Эхэндээ энэ еврейн эсрэг үзэл колончилогдож байсан оронд өрнөсөн бол сүүлдээ өргөжин Европод газар авав. Еврей нар европжиж европын улсуудын улс төрийн амьдралд оролцож эхэлсэн нь тэр улсуудын Засгийн газрын еврейн эсрэг атаархах үзлийг гааруулсан юм. Ийнхүү нутаг уснаасаа дайжин энд тэнд тэнүүчлэн

амьдарсан еврей иргэд ад үзэгдэн хэрхэн зовсоор ирснийг дэлхийн 2-р дайны үеэрх үйл явдал бэлхэн гэрчлээд өгөх буйзаа.

НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1947 оны 11-р сарын 29-ний хуралдаанаар Дэлхийн 2-р дайнд хамгийн их зовсон еврей иргэдийг нэгтгэн нэг улс байгуулах шийдвэр гаргаснаар Израйль улс бий болов. Энэ улсыг арабын Палестины нутаг дэвсгэр дээр байгуулахаар НҮБ шийдвэрлэжээ. Уугуул нутагтаа амгалан аж төрж байсан палестин иргэд гэнэт НҮБ-ын шийдвэрээр нутгаасаа ийнхүү хөөгдөв. Эцэг өвгөдөөсөө уламжлан авч ирсэн газар, ус, нутаг аж ахуй тариаланг нь Израйль улс түрэмгийлэн эзэлээд иргэдийг нь өөр газар руу шахан хөөлөө. Гэнэт л өөрийн гэсэн бүхнээсээ салж ядууралд автан хоосорсон палестинчууд эцэс төгсгөлгүй өс хонзонд ийнхүү автагдсан түүхтэй.

1948-1964 он –Цөлөгөөс Үндэсний хөдөлгөөн **хүртэлх он жилүүд**

Нутаг уснаасаа хөөгдөн цөлөгдсөн 750-800 мянган палестин иргэд Иордан, Ливанд тархан орогнов. Энэ явдлыг Палестин иргэд “накба” буюу аюумшиг хэмээн нэрлэдэг. Өш хонзон дургүйцэлд ясандаа хүртэл автсан палестинчуудын дунд үндэсний ухамсар хүчтэй болсоор ирэв. 1950-иод оны үеэс Ойрхи Дорнодын залуус улам улс төржиж арабын үндсэрхэг нам, улс төрийн хөдөлгөөнд олноороо элсч эхэллээ. Палестины сэхээтнүүд олноороо “Нэгдэл, Чөлөөлөлт, Өс хонзон” хэмээх уриатай Арабын үндэсний хөдөлгөөнд элсчээ.

Тэдгээр залуусын дунд Бейрут дах америкийн их сургуулийн оюутан Христос шашинт Жорж Хабаш 1968 онд өөрийн анд Наяев Хаваметтай хамтран Палестины ардын чөлөөлөх фронтыг үндэслэв. Эдгээр залуусын зорилго нь араб бүх орнуудыг нэгтгэн чөлөөлөх хөдөлгөөн бий болгож израйлиар дамжуулан колончилж буй америк европын түрэмгийллийг эцэс болгох явдал ажээ.

1959 онд Кувейтэд Фатах хэмээх хөдөлгөөн үүсгэн байгуулагчдын дунд палестин гаралтай Ясер Арафат, Абу Жиад, Абу Ияд хэмээх залуус байв. Олонх нь Газын зурваст цөлөгдөн гарч Израйлийн төмөр мэт хатуу бодлого, зэр зэвсэгт нь ясандаа хүртэл шархалсан залуус ажээ. Газын зурвас газар тэдний хувьд Палестин нутгийн шархалсан дүр төрх. Энэ хөдөлгөөн нутгаас нь хол анх Кувейтээс гаралтай ажээ. Кувейтээс тэд санхүүгийн болон зэр зэвсгийн үүсвэрээ бий болгосон байна. Ийнхүү 1965 онд Палестины чөлөөлөх хөдөлгөөний тэмцэл эхэлжээ.

Федаин нарын тэмцэл 1964-1967

Энэ чөлөөлөх хөдөлгөөн улс төрөөр хийрхсэн хэдхэн хөөрсөн залуусын НҮБ-ын шийдвэрийн эсрэг зогсож хүчирхэг Израйль орныг үгүй хийх гэсэн оролдлого мэтээр гэнэн дүгнэлт хийж үл болно. Энэ хөдөлгөөн палестиныг Израйлаас чөлөөлөх, колоничлогдох явдлыг эцэслэх зорилготой палестин иргэдийн эрх ашгийг хамгаалах, үндэсний ухамсрыг сэргээх, НҮБ-ын тэр үеийн Ерөнхий Ассамблейн гаргасан шийдвэрийг эсэргүүцэж буйгаа дэлхий дахинд мэдээлэх давхар зорилготой байлаа. "Үхэлтэй өрсөн дахин сэргэх" хэмээх утга бүхий felaayin хөдөлгөөн палестины тэмцэгчид зэвсэгт хөдөлгөөнөө эхэлсэн байна. Дайжиж одсон бүх палестинчууд өс хонзонгоор амьсгалж байсан уу гэвэл бас үгүй. Зарим нь нүүж одсон газартаа идээшин дасч зэр зэвсгээс хол байхыг хичээх болцгоожээ. 1970 он гэхэд 25000 гишүүнтэй болсны 15000 нь идэвхитэй байлдагчид ажээ.

Ясер Арафат гэгч хэн бэ?

Мухамед Абдел Рауф Арафат ал-кудва ал-Хусейн гэх урт нэртэй энэ эр 1929 оны 8-р сарын 4-нд Каирт төржээ. Эцэг нь Ерусалимд амьдарч байгаад сүүлд Египетэд халуун ногооны наймаа хийн суурьшжээ. Эх нь ертөнцөөс хальсны хойно Ясер Ерусалимд амьдрах нагац ах дээрээ ирж 1936 онд 7-хон настайдаа анх палестины бослогыг нүдээрээ үзжээ.

Тэрбээр Каирт улс төр судлалын ухаанаар суралцаж 1952 онд Палестины оюутнуудын лигийн удирдагчаар сонгогджээ. 1965 онд Ирак, Алжирийн туслалцаагаар анх Газын зурваст Израйлын цэргийг эсэргүүцэн зэвсэгт хөдөлгөөн өрнүүлснээр Ясерийн намтар Фатах болон Палестины ардын чөлөөлөх хөдөлгөөний түүхтэй холбогдож иржээ.

Ойр дотных нь түүнийг хөгшин гэж хочилдог эдүгээ 74 насыг зооглосон энэ өвгөн Палестины эсэргүүцэх тулалдааны гол зохион байгуулагч XX зууны том улс төрчдийн нэг, дипломатч, цэрэг стратегийн мэргэжилтэн мөн. Тэрбээр Араб түмний тусламж дэмжлэгийг авах, дэлхий нийтэд ард түмнийхээ зүдэргээг ойлгуулахын төлөө цуцалтгүй тэмцэж ирсэн нэгэн ажээ. Тэрээр 1994 онд Ицкак Рабин, Шимон Перес нарын хамтаар энх тайвны Нобелын шагнал хүртсэн аж.

Арабын бусад орнууд Палестинчуудад туслав үү? 1967-1982

Арафатаар удирдуулсан Палестины чөлөөлөх хөдөлгөөн эхэндээ Иордан, Ливаны нутагт үйл ажиллагаагаа төвлөрүүлэн явуулж байв. Энэхүү хөдөлгөөн бослого мөргөлдөөнийг чухалчилсан улс төрийн томоохон бүлэглэл болон хувирсан нь Иордан, Ливаны Засгийн газрын болгоомжлолыг төрүүлснээр барахгүй эцэстээ Египет болон Иордан Израйльтай хэлэлцээ хийн Арафат болон түүний нөхдүүдийг жийж эхэллээ. Арафат ийнхүү мухардаж эхэллээ. Цөхөрдсөн тэмцэгсэд ганцаардаад ирэхээрээ алан хядах үйл ажиллагаагаар өөрсдийнхөө дургүйцлийг илэрхийлэхээр шийдвэрлэсний анхных нь 1972 оны Мюнхений олимпийн тосгонд нэг палестин эр нэвтэрч израйлын тамирчидыг барьцаалав. Эцэст энэ тэнд алан хядах үйл ажиллагаа гаргаснаар дэлхий дахин дургүйцэх талруу хандсан байна. Гэвч Арафатын толгойлсон Фатах бүлэглэл олон улсын алан хядлага явуулахын эсрэг байр суурийг баримталдаг авч хяналтаас гадуур гарсан буюу Арафатыг хүлээн зөвшөөрдөггүй зарим палестинчууд дур зоргоороо авирладаг ажээ.

1970-аад оноос Палестины чөлөөлөх хөдөлгөөн Ливанд суурьшиж Ливан улс дотор тусгаар тогтносон Палестиныг байгуулах “шахав”. Арабын орнуудын Швейцарь хэмээн нэрлэгдсэн Ливан улс тэр үедээ араб орнуудаас хамгийн баян хамгийн өрнөжсөн улс байлаа. Ливан нь олон шашин зэрэгцсэн өвөрмөц орон, нэг хэсэг нь христос маронит шашинтай, нөгөө нь лалын шашинтай арабууд, мөн друз, шит, ортодокс болон юдаист шүтлэгтэй хүмүүс тодорхой хэмжээгээр бий. Лалын шашинтай ливан нар палестин ах дүү нараа дэмжиж нутагтаа энэ хөдөлгөөнийг байлгахын төлөө байсан нь христос болон бусад шашинтнуудын дургүйцлийг илт хүргэж нийгмийн хагаралд хүргэжээ. Ингэснээр энэхүү явдал хөгжиж цэцэглэж байсан Ливан улсыг иргэний дайнд татан орууллаа. Ийнхүү мөргөлдөөнд сүйрсэн Ливан улсад 1976 онд Сирийн арми орж ирж арай гэж зэвсэгт мөргөлдөөнийг эцэс болгов. Ливан ийнхүү 30 жилийн турш Сирийн цэргийн нөлөөн дор оршиж буй ажээ.

1982-1987 Ливанаас Палестинчууд хөөгдөв.

1982 оны хавар Ливаны Засгийн газар Палестинчуудыг орогноулж байхаа болихоор шийдвэрлэж АНУ, Израйлын дэмжлэгийг хүлээсэн нь Палестины чөлөөлөх хөдөлгөөний 15000 байлдагчийг Алжир, Иемен, Тунис руу хотлов. Гэвч өшөө хорсол нь туйлдаа хүрсэн тэдгээрээр байлдагчид Бейрутаас явахынхаа өмнө эмэгтэйчүүд, хөгшид, хүүхэд нийлсэн 3000 ливан хүнийг хайр найргүй хядаад орхилоо.

Энэ үеэс эхлэн өмнөд Ливанд Хазбулах хэмээх Иран, Сири орнуудын цэргийн тусламж дэмжлэгийг хүртсэн шит шашинтай ливанчууд Израйльтай дайсагналцах болжээ. Сири улсын үүрэг ролийг энд тодорхойлох нь хялбар мэт авч бас хэцүү. Хафез ель Ассад гэх алауит хэмээх лалын шашны урсгалыг дагадаг, нийгмийн цөөнхөөс гаралтай генерал 1970-аад онд төрийн эргэлт гаргаж засгийн эрхэнд гарснаас хойш 25 жил Сири улсыг төмөр гараар удирдсан нэгэн билээ.

Хэдийгээр Сири улсад цэргийн диктатур тогтож, улс орон нь ганц хүний хараа хяналтанд орж тахин шүтэх болсон авч Сири улс хөрш орнуудынхаа нэгэн адил дайн дажны аймшгийг үзээгүй юм. Хафез ель Ассад бас нэлээн зальтай эр. Бас Израйлийн хамгийн том дайсан. Израйлыг хэзээ ч хүлээн зөвшөөрч байгаагүй ч Палестинчуудыг найр тавин эх орондоо угтаагүй. Ливаныг эзэлж авангуутаа Израйлтай сөргөж зэвсэгт мөргөлдөөнийг өөрийн нутагтаа бус Ливаны нутагт Хазбуллахаар дамжуулж хэрэгжүүлсээр иржээ. Тэрбээр 2000 оны 5 сард нас барсан нь Сирийн нийгмийг цочоосон үйл явдал болсон юм. Гэвч депутатууд нь 100% саналаар 34 настай хүүг үе залгамжлуулан ерөнхийлөгчөөр сонгожээ.

Интифада 1987-1993

1987 оны 12-р сараас эхлэн цөллөгт олон жил тарчилсан палестинчууд зэр зэвсэггүй ч гэсэн израйлуудыг эсэргүүцэн чулуу нүүлгэх болсон нь чулууны дайн буюу Интифада хэмээн нэрлэгдэх болсон аж. Арафатын анд нар улс улс дамжин хэсүүчлэн Израйлыг энэ тэндээс нь хатгаж байсан бол нэг газар цөлөгдөөд хэдэн 10 жил бохир орчинд зовж зүдэрч өссөн палестинчуудын шинэ залуу үе бий болж Израйльтай өөрөөр үзэхээр шийджээ.

Өлсгөлөн ядуурал тарчилгаанд өссөн, үхэл гэдгээс огт айхгүй өш хонзонгийн дунд амьдарсаар сурч боловсорч, амьдралаа дээшлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх ямарч эрх боломжгүй залуус өдөрт бөөнөөрөө энд тэнд цуглан элдвийг хөөрч, ихэнхдээ израйлаас яаж хонзонгоо авъяа даа хэмээн бодсоор цагийг өнгөрөөдөг шиг санагдсан.

1993-1994 Палестины эрх барих удирдлага

албан ёсоор бий болов.

1993 онд анх Палестин Израиль энхийн хэлэлцээрийг үзэглэсэн нь дэлхий дахины талархал баяслыг хүлээв. Израиль ийнхүү түүхэнд анх удаагаа Палестин гэгч үндэстэн байдгийг албан ёсоор

зөвшөөрөв үү. Палестин анх удаагаа өөрийгөө албан ёсоор тунхаглах нөхцөл бүрдэв үү? Харамсалтай нь энэ явдал асуудлыг бүрэн гүйцэд шийдвэрлэсэнгүй зөвхөн билэг тэмдгийн чанартай болоод өнгөрчээ.

**Энэ хоёр ард түмэн эртнийх шигээ эв найртай
орших үе ирэх үү?**

Ойрхи Дорнодын асуудал бидний үед хүнд хэвээрээ байсаар л байна. Энэ хоёр ард түмэн олон жилийн тулалдааны туршид хуримтлуулсан бие биенээ үзэн ядах үл ойлголцох явдал дахиад нэг хэсэгтээ л үргэлжлэх байх. Зэр зэвсэг агссан дайнд хөөрсөн Израйль палестины дайтагчдын хөлд гэм зэмгүй олон мянган хүн үхэж үрэгдсээр байна. 9-р сарын 11-ний үйл явдлаас хойш Израйль гэм зэмгүй олон палестинчуудыг далимдуулан олноор нь баривчилж ял тулгах боллоо. Зовж доромжлогдож амьдарч байснаас өшөө хонзонгоо илэрхийлээд үхье гэсэн тангарагтай олон палестин залуус өдрөөс өдөрт нэмэгдсээр байна.

Энэ тулалдаанд хэн хожих вэ? Ямар ч атугай Израйль, Палестин хоёрын аль нь ч хожихгүй. Зэвсэг тэдэнд худалдаалан хэтэвчээ дүүргэсэн хэн нэг нь хожсон байж болох юм. Хүний зовлонгоор жаргал хийгсэд хожсон байж магадгүй. Өөр нэг эмзэг асуудал бол Арафатын дараа хэн гарч ирэх бол? Палестиныг хэн төлөөлөх бол? Одоохондоо үүнд хэн ч хариулж мэдэхгүй бөгөөд магадгүй энэ асуултанд хариулт хийх цаг нь болоогүй байж мэдэх юм.

2002 оны 10-р сар. Тулуз хот.Франц

1. /Пальмирийн туурь, Сири улсын нийслэл Дамаскаас 145 км зайд оршдог дэлхийн хамгийн эртний хотын балгас/
2. Угарит хэмээх бичиг эдүгээ хүн төрөлхтөний хамгийн анхны бичиг хэмээгддэг.